**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 26 өдөр          Дугаар А/189          Улаанбаатар хот

Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн
шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллах
Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын 49 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүрэгт "Шүүр" арга хэмжээг зохион байгуулсан ажлын хэсгийн үйл ажиллагааг хянаж шалгах Ажлын хэсгийн дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн дарга: | Б.Болормаа | Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч |
| Гишүүд: | Б.Гэрэлцолмон | Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Гадаад харилцаа, өргөдөл, гомдол хариуцсан ахлах мэргэжилтэн |
| | А.Алтантуяа | Санхүү, төрийн сангийн хэлтсийн Банкны төлбөр тооцоо хариуцсан ахлах мэргэжилтэн |
| | Ө.Амарзаяа | Нийгмийн хөгжлийн хэлтсийн Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, гэр бүл, хүүхэд залуучуудын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн |
| Нарийн бичгийн дарга: | Н.Батцэнгэл | Төрийн захиргааны удирдлагын Хэлтсийн Эрх зүй, хяналт шинжилгээ үнэлгээ, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн |

2.Гишүүдийг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллаж, Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн шаардлагын хүрээнд холбогдох арга хэмжээг авч, авсан арга хэмжээний талаар Засаг даргын Тамгын газрын хамт олонд мэдээлж, хариуг хуулийн хугацаанд хүргүүлэхийг Ажлын хэсэг (Б.Болормаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА          А.СҮХБОЛД

1123000320
AJIL\2023 он ажил\захирамж